

# УЛС, ОРОН НУТАГ, ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН САНХҮҮЖИЛТТЭЙ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН МЭДЭЭЛЛИЙН САМБАРЫН ҮНДЭСНИЙ **MNS 7023 2023** СТАНДАРТ

## ҮНДЭСНИЙ MNS 7023 2023 СТАНДАРТЫГ ХЭН, ХЭРХЭН ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГТЭЙ ВЭ?

Улс, орон нутгийн төсөв болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжих инженерийн барилга байгууламжийн барилгын ажил, гадна тохижилтын ажил бусад бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч этгээд тухайн төсөл, арга хэмжээний ерөнхий мэдээллийг иргэдэд таниулах зорилготой мэдээлэл бүхий зурган самбарыг байршуулах үүрэгтэй.

## “ИНЖЕНЕРИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ” ГЭДЭГТ ДАРААХ ТӨСЛҮҮД БАГТАНА:

### БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛЬ (БТХ)-ИЙН 4.1.1-Т ЗААСАН “БАРИЛГА БАЙГУУЛАМЖ”


Орон сууц, иргэн, үйлдвэр, эрчим хүч, харилцаа холбоо, ус, нефтийн барилга, ус суваг, далан хаалт зэрэг байгууламж түүний инженерийн шугам сүлжээ

### БТХ-ИЙН 4.1.33-Т ЗААСАН “ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЭЦ”

Авто зам, төмөр зам, дүүжин зам, газрын доор, дээр байрлах замын байгууламж, бүх төрлийн инженерийн шугам сүлжээ, гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх энгийн болон инженерийн хийц, бүтээц бүхий байгууламж

### БТХ-ИЙН 4.1.35-Т ЗААСАН “ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭ”

Ус хангамж, цахилгаан, дулаан, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, газрын тос болон төрөл бүрийн хий дамжуулах хоолой, харилцаа холбооны төвлөрсөн байгууламж



### ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН 3.1.9-Т ЗААСАН “ЭРЧИМ ХҮЧНИЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ”

Эрчим хүчний эх үүсвэр, дамжуулах, түгээх шугам, дэд станц болон технологийн зориулалттай бусад байгууламж

### АВТО ЗАМЫН ТУХАЙ ХУУЛЬ(АЗТХ)-ИЙН 4.1.1-Т ЗААСАН “АВТО ЗАМ”

Тээврийн хэрэгсэл зорчиход зориулан барьсан замын байгууламж бүхий хатуу, хайрган хучилттай зам, гудамж

### АЗТХ-ИЙН 4.1.11-Т ЗААСАН “ЗАМЫН БАЙГУУЛАМЖ”

Бүх төрлийн гүүр, тавилан, гүүрэн гарц, унадаг дугуй болон явган зорчигч, хөгжлийн бэрхшээлтэй хүн зорчиход зориулсан зам, ус зайлуулах хоолой, шүүдүү, хонгил, замын хөдөлгөөнийг зохицуулах болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зориулалттай төхөөрөмж, авто замын зурвас газарт байгаа төлбөр авах цэг, авто зогсоол болон бусад байгууламж

